МОНГОЛ УЛСЫН
БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЯАМ

Засгийн газрын XII байр, 4 дүгээр хороо,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15170
Утас: (976-11) 31 06 12, 7600 3333-1126
Факс: (976-11) 32 29 04
Цахим шуудан: info@mcud.gov.mn
Цахим хуудас: www.mcud.gov.mn

2024.01.16 № 6/141

танай ______-ны № ______-т

ЭРЧИМ ХҮЧНИЙ ЯАМНЫ САНХҮҮ,
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ГАЗРЫН
ДАРГА З.МӨНХ-ОРГИЛ ТАНАА

Дулааны шугамын өргөтгөлийн тухай

Монгол Улсын Засгийн газрын болон АНУ-ын Мянганы сорилтын корпорац хооронд байгуулсан II Компакт гэрээнд “Улаанбаатар хотын ус хангамжийг нэмэгдүүлэх төсөл”-ийн хүрээнд Ус гүн цэвэршүүлэх үйлдвэр, Хаягдал ус дахин боловсруулах үйлдвэр, мөн БНХАУ-ын Экспорт-Импорт банк хооронд байгуулсан 2020/497 дугаартай тусгайлсан зээлийн хэлэлцээрийн дагуу “Улаанбаатар хотын төв цэвэрлэх байгууламжийг шинээр барих төсөл”-ийн барилгын гадна дулаан хангамжийн зураг төслүүдийг боловсруулж, магадлалаар баталгаажуулсан.

Дээрх төслүүдийн ажлын дулаан хангамжийг 2024-2025 оны халаалтын улиралд ашиглалтад оруулах зайшгүй шаардлага үүсч байгаа бөгөөд Сангийн сайдын 2023 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн “Жагсаалт батлах тухай” 230 дугаар тушаалаар Хаягдал ус дахин боловсруулах үйлдвэрийн барилга болон Шинэ төв цэвэрлэх байгууламжийн барилгын гадна дулаан хангамжийн шугамын ажил, мөн сайдын 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн “Жагсаалт шинэчлэн батлах тухай” 247 дугаар тушаалаар Ус гүн цэвэршүүлэх үйлдвэрийн барилгын гадна дулаан хангамжийн шугамын санхүүжигдэх төсөвт өртгийг тусгаж, зарцуулах эрхийг танай яаманд шилжүүлэхээр шийдвэрлэсэн байна.

Мянганы сорилтын хоёр дахь Компакт гэрээнд заасны дагуу Монгол Улсын Засгийн газар нь хүлээсэн үүргээ биелүүлээгүй бол Мянганы сорилтын корпорацаас Компакт гэрээний үйлчлэл, санхүүжилтийг нэн даруй бүхэлд нь болон хэсэгчлэн түр зогсоох, эсхүл хүчингүй болгохоор заагдсан. Уг гэрээгээр Ус гүн цэвэршүүлэх үйлдвэр 2024 онд, Улаанбаатар хотын шинэ төв цэвэрлэх байгууламж болон Хаягдал ус дахин

152450233

Нийлсэн: Т.Сувд-Эрдэнэ

Боловсруулсан: Т.Сувд-Эрдэнэ

3 хувь Н.У

2024.01.15 11:37:30

F:\Бичгийн төсөл\Бичгийн төсөл 2023

боловсруулах үйлдвэрийг 2025 онд ашиглалтад оруулах төлөвлөгөөтэй ажиллаж байгаа бөгөөд ашиглалтад оруулах хугацааг хатуу тогтсон болно.

Иймд “Улаанбаатар хотын Сонгинохайрхан дүүргийн 32-р хорооны нутаг дэвсгэр дэх Ус гүн цэвэршүүлэх үйлдвэрийн гадна дулааны шугам”, “Дулааны 9Б магистраль, цэвэрлэх салаа ДХ935-ДХ935-9 хүртэлх 2ф300-ийн 745 хос метр шугамыг 2ф400/500 болгон өргөтгөх шинэчлэх” ажлуудыг цаг алдалгүй хэрэгжүүлэх талаар холбогдох арга хэмжээг авч ажиллахыг хүсье.

Хувийг: Монголын мянганы сорилтын санд.

Хавсралт .5... хуудастай.

БАРИЛГА, БАРИЛГЫН МАТЕРИАЛЫН ҮЙЛДВЭРЛЭЛИЙН
БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТИЙГ ЗОХИЦУУЛАХ
ГАЗРЫН ДАРГА Д.ГАНТУЛГА

# МОНГОЛ УЛСЫН САНГИЙН САЙДЫН ТУШААЛ

2023 оны 12 сарын 12 өдөр Дугаар 230 Улаанбаатар хот

Жагсаалт батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 14.4 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Монгол улсын 2024 оны төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралт "Монгол Улсын төсвийн хөрөнгөөр 2024 онд санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалт"-ын Сангийн сайдын багцад батлагдсан IX.2.1.2 "Гадаадын зээл, тусламжаар хэрэгжих төслүүдийн Монголын талын хөрөнгө оруулалт /улсын хэмжээнд/" төслийн хүрээнд санхүүжигдэх төсөл, арга хэмжээний жагсаалтыг хавсралтаар баталсугай.

2. Энэ тушаалын хавсралтаар батлагдсан төсөл, арга хэмжээний төсвийн зарцуулах эрхийг холбогдох төсөл хэрэгжүүлэгч байгууллагад шилжүүлсүгэй.

3. Төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулж, хяналт тавих, хэрэгжилтийг тайлагнахыг төсөл хэрэгжүүлэгч байгууллагад үүрэг болгосугай.

4. Батлагдсан төслийг холбогдох журмын дагуу санхүүжүүлэхийг Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газар /Ч.Чимидсүрэн/-т даалгасугай.

5. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга /Ж.Ганбат/-д даалгасугай.

Б.ЖАВХЛАН

9763000770

Сангийн сайдын 2023 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн 430 дугаар тушаалын хавсралт

**"Гадаадын зээл, тусламжаар хэрэгжих төслүүдийн монголын талын хөрөнгө оруулалт /улсын хэмжээнд/" төслийн хүрээнд санхүүжигдэх төсөл, арга хэмжээний жагсаалт**

/сая.төгрөг/

| Дугаар | Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил | Хугацаа | | Төсөвт өртөг | 2024 онд санхүүжих дүн |
|---|---|---|---|---|---|
| | | Эхлэх | Дуусах | | |
| | **ЭРЧИМ ХҮЧНИЙ САЙД** | | | **3,176.2** | **3,176.2** |
| IX.2.1.2.1 | АНУ-ын Мянганы сорилтын сангийн тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж буй "Улаанбаатар хотын ус хангамжийг нэмэгдүүлэх төсөл"-ийн Монголын талын хөрөнгө /9Б магистраль, дулааны шугамыг өргөтгөн шинэчлэх ажил, Улаанбаатар/ | 2024 | 2024 | 3,176.2 | 3,176.2 |

**МОНГОЛ УЛСЫН САНГИЙН САЙДЫН**
**ТУШААЛ**

2023 оны 12 сарын 25 өдөр Дугаар 247 Улаанбаатар хот

**Жагсаалт шинэчлэн батлах тухай**

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 14.4 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралт "Монгол Улсын төсвийн хөрөнгөөр 2023 онд санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалт"-ын Сангийн сайдын багцад батлагдсан VI.2.1.2 "Гадаадын зээл, тусламжаар хэрэгжих төслүүдийн Монголын талын хөрөнгө оруулалт /улсын хэмжээнд/" төслийн хүрээнд санхүүжигдэх төсөл, арга хэмжээний жагсаалтыг хавсралт ёсоор шинэчлэн баталсугай.

2. Энэ тушаалын хавсралтаар батлагдсан жагсаалтын VI.2.1.2.5-д тусгагдсан төсөл, арга хэмжээний төсвийн зарцуулах эрхийг Хөгжлийн хөтөч-дэд бүтэц төсөл /Ж.Ганбаатар/-д, VI.2.1.2.6-д тусгагдсан төсөл, арга хэмжээний төсвийн зарцуулах эрхийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар /Б.Цэнгэл/-т, VI.2.1.2.7-д тусгагдсан төсөл, арга хэмжээний төсвийн зарцуулах эрхийг Монголын Мянганы сорилтын сан /Э.Энхгэрэл/-д, бусад төсөл арга хэмжээний төсвийн зарцуулах эрхийг холбогдох төсөл хэрэгжүүлэгч байгууллагад тус тус шилжүүлсүгэй.

3. Төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулж, хяналт тавих, хэрэгжилтийг тайлагнахыг Хөгжлийн хөтөч-дэд бүтэц төсөл /Ж.Ганбаатар/-д, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт, Монголын Мянганы сорилтын санд, төсөл хэрэгжүүлэгч байгууллагад тус тус үүрэг болгосугай.

4. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан "Жагсаалт шинэчлэн батлах тухай" Сангийн сайдын 2023 оны 07 дугаар сарын 06-ны өдрийн 143 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

5. Батлагдсан төсвийг холбогдох журмын дагуу санхүүжүүлэхийг Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газар /Ч.Чимидсүрэн/-т даалгасугай.

6. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга /Ж.Ганбат/-д даалгасугай.

Б.ЖАВХЛАН

9763000380

*Сангийн сайдын 2023 оны 10 дугаар сарын 25-ны*
*өдрийн 240 дугаар тушаалын хавсралт*

## "Гадаадын зээл, тусламжаар хэрэгжих төслүүдийн монголын талын хөрөнгө оруулалт /улсын хэмжээнд/" төслийн хүрээнд санхүүжигдэх төсөл, арга хэмжээний жагсаалт

*/сая төгрөг/*

| Дугаар | Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил | Хугацаа | | Төсөвт өртөг | 2023 онд санхүүжих дүн |
|---|---|---|---|---|---|
| | | Эхлэх | Дуусах | | |
| | **ЭРЧИМ ХҮЧНИЙ САЙД** | | | **127,819.6** | **50,649.6** |
| VI.2.1.2.1 | АНУ-ын Мянганы сорилтын сангийн тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж буй "Улаанбаатар хотын ус хангамжийг нэмэгдүүлэх төсөл"-ийн Монголын талын хөрөнгө /гадна цахилгаан хангамж, Улаанбаатар/ | 2023 | 2024 | 51,756.1 | 32,437.3 |
| VI.2.1.2.2 | АНУ-ын Мянганы сорилтын сангийн тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж буй "Улаанбаатар хотын ус хангамжийг нэмэгдүүлэх төсөл"-ийн Монголын талын хөрөнгө /гадна дулаан хангамж, Улаанбаатар/ | 2023 | 2024 | 5,100.0 | 50.0 |
| VI.2.1.2.3 | БНХАУ-ын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр хэрэгжиж буй "Төв цэвэрлэх байгууламжийг шинээр барих төсөл"-ийн Монголын талын хөрөнгө /цахилгаан хангамж, Улаанбаатар/ | 2023 | 2024 | 29,026.8 | 18,083.8 |
| VI.2.1.2.4 | БНХАУ-ын зээлийн хөрөнгөөр хэрэгжиж буй "Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц барих төсөл"-ийн Монголын талын хөрөнгө /Ховд/ | 2023 | 2028 | 41,936.7 | 78.5 |
| | **САНГИЙН САЙД** | | | **101,252.9** | **94,260.0** |
| VI.2.1.2.5 | БНХАУ-ын тусламжаар хэрэгжиж буй "Хилийн боомтын дэд бүтэц төсөл"-ийн Монголын талын хөрөнгө /Дорноговь, Замын-Үүд боомт, Өмнөговь, Гашуунсухайт боомт/ | 2022 | 2023 | 17,820.6 | 10,827.7 |
| VI.2.1.2.6 | БНХАУ-ын тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж буй "Буянт-Ухаа спортын ордны засварын төсөл"-ийн Монгол талын хөрөнгө /Улаанбаатар/ | 2023 | 2023 | 79.0 | 79.0 |
| VI.2.1.2.7 | АНУ-ын Мянганы сорилтын сангийн тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж буй "Улаанбаатар хотын ус хангамжийг нэмэгдүүлэх төсөл"-ийн Монголын талын хөрөнгө /Улаанбаатар/ | 2023 | 2023 | 83,353.3 | 83,353.3 |
| | **БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН САЙД** | | | **11,264.0** | **9,250.0** |
| VI.2.1.2.8 | БНХАУ-ын тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж буй "1008 айлын орон сууц барих төсөл"-ийн Монголын талын хөрөнгө /Улаанбаатар/ | 2023 | 2024 | 4,129.0 | 2,115.0 |
| VI.2.1.2.9 | БНХАУ-ын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр хэрэгжиж буй "Төв цэвэрлэх байгууламжийг шинээр барих төсөл"-ийн Монголын талын хөрөнгө /Улаанбаатар/ | 2023 | 2023 | 7,135.0 | 7,135.0 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | **НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА** | | | **5,501.8** | **1,772.0** |
| VI.2.1.2.10 | БНХАУ-ын зээлийн хөрөнгөөр хэрэгжиж буй "Гачууртын уулзвараас Налайх-Чойрын уулзвар хүртэлх 20.9 км авто зам барих төсөл"-ийн Монголын талын хөрөнгө /Улаанбаатар/ | 2023 | 2023 | 173.0 | 173.0 |
| VI.2.1.2.11 | БНХАУ-ын зээлийн хөрөнгөөр хэрэгжиж буй "Нүхэн гарц төсөл"-ийн Монголын талын хөрөнгө | 2023 | 2024 | 5,328.8 | 1,599.0 |
| | **ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД** | | | **4,024.7** | **4,024.7** |
| VI.2.1.2.12 | БНСУ-ын зээлээр хэрэгжиж буй "Үндэсний оношилгоо эмчилгээний төв байгуулах төсөл"-ийн Монголын талын хөрөнгө /Улаанбаатар/ | 2023 | 2023 | 2,745.7 | 2,745.7 |
| VI.2.1.2.13 | Арабын Эдийн Засгийн Хөгжлийн Кувейтийн сангийн тусламжаар хэрэгжиж буй "Түлэнхийн төвийн барилга барих төсөл"-ийн Монголын талын хөрөнгө | 2023 | 2023 | 1,279.0 | 1,279.0 |
| | **БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЙД** | | | **2,608.5** | **2,150.0** |
| VI.2.1.2.14 | ХБНГУ-ын тусламжаар хэрэгжиж буй "Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох төсөл"-ийн Монголын талын хөрөнгө | 2023 | 2024 | 1,500.0 | 1,350.0 |
| VI.2.1.2.15 | БНСУ-ын тусламжаар хэрэгжиж буй " Монгол Улсын аялал жуулчлалын сургалтын төв байгуулах, салбарын хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх төсөл "-ийн Монголын талын хөрөнгө | 2023 | 2024 | 1,108.5 | 800.0 |
| | **БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ САЙД** | | | **21.0** | **21.0** |
| VI.2.1.2.16 | АНУ-ын тусламжаар хэрэгжиж буй "50 ортой хүүхдийн цэцэрлэгийн барилга барих төсөл"-ийн Монголын талын хөрөнгө /Сүхбаатар, Эрдэнэцагаан сум, Сэлэнгэ, Сүхбаатар сум, Увс, Баруунтуруун сум/ | 2023 | 2023 | 21.0 | 21.0 |
| | **НИЙТ ДҮН** | | | **252,492.5** | **162,127.3** |